



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/471

Улаанбаатар хот

«Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Ажлын албаны данс бүртгэлээс
тээврийн хэрэгсэл хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/821 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газраас 2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулсан нээлттэй дуудлагын худалдаагаар худалдсан 30,000,000.0 /гучин сая/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий Вольксваген жетта маркийн 00-37 УНК улсын дугаартай тээврийн хэрэгслийг данс бүртгэлээсээ хасахыг Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ж.Ичинноров/-нд зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /Ж.Ичинноров/-нд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтэс /М.Мандах/-т тус тус даалгасгай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ